



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 05 сарын 07 өдөр

Дугаар 1/40

Улаанбаатар хот

(SARS –Cov-2)- вирус халдварт өвчнөөс сэргийлэх, өндөржүүлсэн бэлэн байдлыг ханган ажиллах тухай


Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын “в”, 29.2, 39 дүгээр зүйлийн 39.1, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5, 32 дугаар зүйлийн 32.1.2 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 05 дугаар сарын 12- ны өдрийн 01, 02, 03 тоот захирамж, Нийслэлийн онцгой комиссын даргын 2020 оны 05 сарын 12-ны 01 тоот тушаал, Нийслэлийн онцгой комиссын 2020 оны 05 сарын 06-ны 01 тоот хурлын тэмдэглэл, Хан-Уул дүүргийн засаг даргын 2020 оны 05 сарын 06-ны А/01 тоот захирамж, 2020 оны 05 сарын 19-ний 04 тоот захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. (SARS –Cov-2)- вирус халдварт өвчин гарсантай холбогдуулан хүн амын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлж өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлсүгэй.
2. SARS –Cov-2)- вирус халдварт өвчнөөс сэргийлэх өндөржүүлсэн бэлэн байдлыг хангах эрсдэлийг бууруулах ажлыг тогтмол зохион байгуулах, эмнэлгийн тусламж үйлчилгээ, яаралтай тусламжийн болон шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тусгаарлах өрөө, орны нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангаж ажиллахыг хэвтэн эмчлүүлэх тасгийн эрхлэгч /Б.Шинэхүү/-д даалгасугай.
3. Халдварт өвчний тохиолдлыг эрт сэрэмжлүүлэх, хариу арга хэмжээний тандалтын журмын дагуу SARS –Cov-2)- вирус халдварын болзоцгүй тохиолдлыг эрт илрүүлж, SARS –Cov-2)- вирус халдварын тохиолдлын тархвар судалгааны хуудсаар мэдээлэх, халдварын сэргийлэлт, хяналтын багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, эмнэлгийн халдварын сэргийлэлт, хяналтын дэглэмийг чанд мөрдөх, сэжигтэй тохиолдлын үед өвчтөн болон ойрын хавьтагсаас сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэлтэд ЭМС-тушаал, зөвлөмжийг мөрдөж ажиллах, Эрүүл мэндийн зөвлөгөө, халдвараас урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, зөвлөмж өгөх ажлыг зохион байгуулах, албан хаагчид, үйлчлүүлэгчдийг гараа халдваргүйжүүлэх нөхцөлөөр хангах, амны хаалтын хэрэглээг хэвшүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг ахлах тархвар судлаач /С.Өлзийжаргал/-д даалгасугай.

30170 70 0311

4. (SARS –Cov-2)- вируст халдвараас урьдчилан сэргийлэх заавар зөвлөмж, сэрэмжлүүлгийг иргэд, хамт олон, албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд түгээх, мэдээлэл сургалт сурталчилгааны ажлыг өргөнөөр зохион байгуулах, Өрхийн эрүүл мэндийн төвийн тусламж үйлчилгээ, халдварын сэргийлэлт хяналтын багийн үйл ажиллагааг мэргэжил арга зүйгээр ханган ажиллахыг Нийгмийн эрүүл мэндийн орлогч дарга /Б.Лувсанням/-д даалгасугай.
5. (SARS –Cov-2)- вируст халдварын болзошгүй тохиолдлын үед Олон улсын хөл хориот, Нийгмийн эрүүл мэндэд ноцтой байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөөний дагуу бэлтгэл, бэлэн байдлыг хангах, эм, эмнэлгийн хэрэгслийн холбогдолтой зардлыг зохих данснуудаас гаргаж нөөц бүрдүүлэхийг Ерөнхий нягтлан бодогч /С.Оюунцэцэг/-д үүрэг болгосугай.
6. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эмчилгээ эрхэлсэн орлогч дарга /Т.Гэрэлсүрэн/-д даалгасугай.

ДАРГА



Э.БОДЬЦЭЦЭГ